

Сэтгүүлд бүтээлээ илгээхийг урьж байна

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Эдийн засгийн тэнхимээс эрхлэн гаргадаг “ЭДИЙН ЗАСАГ: ОНОЛ, ПРАКТИК” сэтгүүлд судалгааны бүтээлээ илгээхийг урьж байна.

Сэтгүүлийг анх эрхлэн гаргасан он: 2000

Эрхэм Зорилго: *Эдийн засгийн судалгааны чанарыг дэлхийн түвшинд хүргэх*

Зорилт болон Хамрах хүрээ:

Сэтгүүл-ийн гол зорилт бол Монголын эдийн засаг, түүний дэлхийн эдийн засагтай хэрхэн холбогдож буй талаар онолын болон эмпирик судалгаануудыг шүүн магадлаж, өндөр чанартай судалгааны ажлуудыг хэвлэн нийтлэх явдал юм.

Хэл:

Сэтгүүлийн хэл нь Монгол, Англи хэл байна. Абстракт нь англи, монгол хэл дээр байна.

Хэвлэлт

Жилд хоёр дугаар хэвлэгдэх ба судалгааны ажлуудад хөндлөнгийн шүүлт хийн, нэг удаагийн дугаарт шаардлага хангасан 3-5 ажил хэвлэнэ.

Сэтгүүлд хэвлүүлэх бүтээлд тавигдах шаардлага:

1. Судалгааны ажлын эхийг Монгол болон Англи хэл дээр өгч болно. Монгол хэл дээрх судалгааны ажлын хувьд абстрактыг Монгол болон Англи хэл дээр бичсэн байна.
2. Судалгааны ажлын формат: мөр хоорондын зай нь 2, фонтны хэмжээ 12, А4-ийн хэмжээтэй, microsoft word, latex аль алин дээр нь байж болно. Хуудсыг дугаарласан байна. Үгийн тоо 8000-аас хэтрэхгүй.
3. Сэтгүүлд хэвлэгдэхээр шалгарсан ажил latex програм дээр бичигдсэн байна.
4. Судалгааны ажлын эхний нүүрэнд дараах мэдээллийг зайлшгүй оруулна. Үүнд: (i) Судалгааны ажлын нэр; (ii) Зохиогч, хамтарсан бүтээл бол хамтран зохиогчдын нэр (iii) Харьяа байгууллагын нэр; (iv) Хамгийн ихдээ 150 үгэнд багтаасан судалгааны ажлын товчлолыг (абстракт) оруулсан байна. Абстрактыг Англи, Монгол хэл дээр өгнө; (v) Түлхүүр үгсийг JEL кодтой оруулсан байх; (vi) гол холбоо барих зохиогчийн хаяг, талархал, санхүүжүүлэгчийн мэдээлэл зэргийг зүүлтээр (footnote) оруулна.
5. Томъёог баруун талд нь (1), (2), гэх мэтээр дугаарлана. Ямар нэг томъёоны гаргалгааг товчилж оруулсан бол бүтэн гаргалгааг нь тусдаа хуудсанд оруулсан байвал зохино. Томъёоны гаргалгааг хэвлэх хувилбарт оруулахгүй зөвхөн ажлыг унших шүүгчид ашиглана.
6. Хүснэгт болон графикуудыг тус бүрт нь харгалзах нэртэй нь дугаарласан байна.

7. Текстэн дунд өөр судалгааны ажлаас иш татахдаа зохиогчийн нэр, хаалтан дотор судалгааны ажил, хэвлэгдсэн оныг оруулах байдлаар иш татна. Жишээ нь "... Anderson(1972) ажилд..." эсвэл хаалтанд бичих байдлаар "... (e.g., Smith *et al.*, 1969)" гэх мэт. Ашигласан материалын жагсаалтыг гол текстийн ард оруулна. Ашигласан материалын жагсаалтыг доор харуулснаар, Англи хэл дээрх эх сурвалжийн хувьд зохиогчдын өвгийн эхний үсгийн, Монгол хэл дээрх эх сурвалжийн хувьд зохиогчдын нэрсийн үсгийн дарааллаар бичнэ.
8. Зохиогчид редакцын зөвлөлийн хүсэлтийн дагуу судалгааны ажилд ашигласан тоон өгөгдөл, програм ашигласан бол эх кодоо гаргаж өгнө.

Сэтгүүлийн шүүлтийн тогтолцоо:

Олон улсын нэр хүндтэй сэтгүүлүүдийн нэгэн адил зохиогчоос шүүгчийнх нь нэрийг нууцладаг системээр бүтээлийг шүүнэ.

- Ерөнхий редактор бүтээлд тавигдах наад захын шаардлага хангагдаагүй гэж үзвэл нийтлүүлэхээр өгсөн бүтээлийг шууд буцааж болно.
- Ерөнхий редактор нийтлүүлэхээр өгсөн бүтээлийг зөвлөлийн гишүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр буцаах шийдвэр гаргаж болно.
- Редакцийн зөвлөлөөр зөвшөөрөгдсөн ажлуудыг тухайн сэдвээр нарийн мэргэшсэн хамгийн багадаа нэг шүүмжлэгч рүү шүүлгэхээр илгээнэ.
- Шүүмжлэгчийг редакцийн зөвлөл хөндлөнгийн оролцоо, нөлөөгүйгээр өөрсдийн бүрэн эрх мэдлийн хүрээнд зөвшилцөн сонгоно.

Сэтгүүлийн түгээлт, хамрах хүрээ

Сэтгүүлийг яам, агентлагууд, судалгааны байгууллагууд, номын сангууд, их сургуулиуд болон олон нийтэд түгээнэ. Сэтгүүл хэвлэмэл бөгөөд цахим хэлбэрээр түгээгдэнэ.

Хэвлэмэл хувилбар

Сэтгүүл нийтдээ 300 хувь хэвлэгдэнэ. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхий редактор хэвлэх тоог өөрчлөн тогтооно.

Электрон хувилбар

Сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлүүдийг өөрийн цахим хуудас дээр нээлттэй тавина. Сэтгүүлийг цахим шуудангаар нийтэд түгээнэ.

Сэтгүүлийн цахим хувилбар нь уламжлалт нийтлэлүүдээс гадна зохиогчийн алгоритм, програм, болон ашигласан тоон мэдээллийг мөн нийтлэх боломжтой бөгөөд ингэснээр бусад судлаачид болон хэрэглэгчид академик ололтыг давтан гүйцэтгэх, өргөтгөх боломжоор хангагдана. Иймд зохиогчдоос эмпирик үр дүнг нь дуурайлган гүйцэтгэхэд шаардагдах тоон мэдээлэл болон програмын хуулбарыг цахим хэлбэрээр авна.

Хаяг: МУИС-ийн хичээлийн 5-р байр, 603 тоот (Б.Батдэлгэр), 608 тоот (Д.Дашдулам).

Цахим хаяг: batdelger@num.edu.mn

Утас: 77307730 (2311) (Б.Батдэлгэр), 77307730 (2303) (Д.Дашдулам).

Редакцийн зөвлөл

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ

МУИС-ийн Эдийн засгийн тэнхим нь анх 1954 онд Улс төр эдийн засгийн ухааны тэнхим нэртэйгээр байгуулагдан, 1994 оноос Эдийн засгийн онолын тэнхим, 2014 оноос Статистик, Хүн ам зүйн тэнхимүүдтэй нэгдэн өргөжиж Эдийн засгийн тэнхим нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус тэнхим нь эдийн засагч мэргэжлээр бакалавр, магистр, докторын түвшинд, хүн ам зүйн чиглэлээр магистр, докторын сургалтыг эрхлэн явуулдаг; макро, микро эдийн засаг, хөгжлийн эдийн засаг, мөнгөний бодлого, санхүүгийн экономикс, бүс нутгийн эдийн засаг, эдийн засгийн бодлого судлал, хөдөлмөр эрхлэлт, хүн ам ба хөгжлийн бодлого, төлөвлөлт гэх зэрэг өргөн хүрээний асуудлуудаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг гүйцэтгэдэг; мэргэжлийн 2 сэтгүүлийг эрхлэн гаргадаг МУИС-ийн судалгаа, эрдэм шинжилгээний хамгийн өндөр чадавх бүхий тэнхимүүдийн нэг юм.

2017-2018 оны хичээлийн жилд бакалаврын болон төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж буй нийт 500 орчим оюутан, 32 багш (үүнээс 56% нь доктор цолтой), сургалтын туслах ажилтан 2, лаборант 1 гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Тэнхимийн профессор, дэд профессор багш нарын дийлэнх нь АНУ, Их Британи, Япон, БНСУ зэрэг хөгжингүй орнуудын тэргүүлэх их сургуулиудад докторын зэрэг хамгаалсан бөгөөд МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэн, Хүн ам зүйн сургалт судалгааны төв гэх мэт 4 хүрээлэн, төвүүдэд харьяалагдан ажиллаж байна.